



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 16

Мандалговь

Г 7
“Төрийн албаны тэргүүний ажилтан” шагналд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнах журмын 3 дугаар бүлгийн 3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төрийн албанд олон жил идэвхи санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж, орон нутагт төр засгийн бодлого шийдвэр, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, үр дүн гаргаж байгаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоож, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Ш.Төрбат, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Нарантуяа нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

Хоёр. Дээрх хүмүүсийн шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

380021018